



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/АЧО

Булган сум

Г Газрын хэмжээ өөрчлөх тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн М.Баяртогтох (ФБ74012073)-ын Булган сум 6 дугаар баг Залуус 14 дүгээр гудамж 1402 тоотод байршилтай 6308002918 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 600 м2 газрыг 718 м2 болгон илүү талбайн дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн кадастрын зураглалын дагуу газрын хэмжээг өөрчилсүгэй.

2. М.Баяртогтохтой газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 76 дугаар захирамжийн М.Баяртогтохтой холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР